



ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ ХАНГАХАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ

CONTEMPORARY CHALLENGES AND LEGAL REMEDIES IN ENSURING THE RIGHT TO A FAIR TRIAL

Наранбаатарын Сайнбаяр*

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч

Pol. Maj. Sainbayar Naranbaatar, Ph.D, Associate Professor, Department of Criminal Procedure Law, Police School, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: sainaa14336@gmail.com

Хураангуй: Хүний эрхийн зөрчил зөвхөн процессын эрх зүйн хамаарах асуудлын хүрээнд үүсдэг болохыг судалгааны үр дүнд тогтоож чадсан. Тодруулбал, материаллаг эрх зүйн хүрээнд хүний эрхийн зөрчил яригддаггүй бөгөөд түүнийг хангаж, хамгаалсан хэм хэмжээний хэрэгжилтийн явцад хүний эрхийн зөрчил ихээр үйлдэгддэг аж. Мөн хэдийгээр материаллаг эрх зүйд хүний эрхийн зөрчил бүхий хэм хэмжээ тусгагдсан байлаа ч түүнийг хэрэгжүүлэхгүй бол хүний эрхийг зөрчсөн гэж үзэх боломжгүй.

Эрүүгийн процессын хууль, тогтоомжид хүний эрхийг аливаа гэмт хэрэгт хохирсон, холбогдон шалгагдах явцад оролцогчдын эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой зааж өгсөн. Ойлгомжтой зааж өгсөн боловч практик онцлогоос шалтгаалж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн зүгээс чиг үүрэгтээ ашигтай байдлаар эрүүгийн процессын хэм хэмжээг тайлбарлан хэрэглэж, зарим тохиолдолд хэрэглэхгүй байх эс үйлдэхүйгээр бусдын эрх ашгийг зөрчих тохиолдол байсаар байна.

Энэхүү судалгаагаар эрүүгийн процессын хүрээнд хүний эрхийн зөрчил нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй этгээдийн орчинд түгээмэл үүсдэг болохыг хүний эрхийн байгууллагад хандсан гомдлын агуулга, статистик тоо мэдээнд дүн шинжилгээ хийж тодорхойлж чадсан. Хүний эрхийн зөрчил байсаар байгаа бол түүнийг арилгахад чиглэсэн арга замыг эрэлхийлэх нь судалгааны ажлын зорилгыг илэрхийлнэ.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа этгээдийн үндсэн эрхийн баталгаа болсон шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг холбогдох тоон мэдээлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт, үндэсний болоод олон улсын түвшин дэх зохицуулалт зэрэгт судалгаа хийж, үр дүнг үндэслэн гарц, шийдлийг санал болгож байна.

Abstract: The study has shown that human rights violations occur exclusively within the framework of procedural law. Specifically, human rights violations are not discussed within the scope of substantive law; instead, they predominantly arise during the implementation of norms that ensure and protect rights. Furthermore, even if substantive law contains provisions that may violate human rights, failure to implement them cannot be considered as a human rights violation.



Criminal procedural laws and regulations clearly define the sequence of actions aimed at ensuring the rights of participants involved in criminal proceedings, whether as victims or suspects. Despite this clarity, due to the practical circumstances, law enforcement officials often interpret and apply criminal procedural norms in ways that serve their interests. In some cases, they deliberately fail to apply these norms, thereby violating the rights and interests of others.

This study has determined, through an analysis of complaints submitted to human rights organizations and statistical data, that human rights violations most commonly occur in the context of individuals under investigation for criminal offenses. Since such violations persist, identifying solutions to eliminate them is a key objective of this research.

By examining the implementation of the right to a fair trial—a fundamental safeguard for individuals accused of crimes—along with related statistical data, criminal procedure enforcement, and national and international regulations, this study provides findings and proposes solutions to address the identified issues.

Түлхүүр үгс: Шударга шүүхээр шүүлгэх, шударгаар шүүлгэх эрх, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх.

Keywords: Having a right to a fair trial, the right to a fair trial, the right of the suspect, the accused and the defendant.

Удиртгал

Хүний эрхийг хангаж, хамгаалах нь төрийн үндсэн чиг үүрэг мөн. Гэвч төрийн олон төрлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч хүний эрхийн хэрэгжилт харилцан адилгүй, хүний эрхийн талаарх ойлголт нэгдмэл бус байдал нь хэрэгжилтэд нь хүндрэл учруулдаг.

Хүний эрхийн нэгдсэн ойлголт нь түүнийг ямар ч үед хангах, хамгаалах оновчтой тогтолцоо бий болоход ач тустай. Жам ёсны эрхийн нэг онцгой төрөл нь шударгаар шүүлгэх эрх мөн. Шударгаар шүүлгэх эрхийн талаар нэгдсэн ойлголтгүйгээс эрүүгийн процессын явцад хүний эрх зөрчигдөх эрсдэлийг бий болгосоор байна.

Шударгаар шүүлгэх эрхийн чухал бүрэлдэхүүнд “эрүү шүүлтээс ангид байх” эрхийн хэрэгжилтийн асуудал чухал байр суурь эзэлнэ. Эрүүл шүүлтээс ангид байх эрх нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх үйл явцад бусдыг эрхийг хязгаарлахгүй гэсэн баталгаа, олон улсын өмнө хүлээсэн үүрэг.

Эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах талаар үндэсний болоод олон улсын түвшинд механизмуудыг бүрдүүлсээр байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 3452 дугаар тогтоолоор “Бүх этгээдийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай” тунхаглал гаргасан ба энэ тунхаглалын зорилгыг бодитой хангахын тулд мөн Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг албан ёсоор батлан гаргасан. Манай улс 2000 онд энэ конвенцод нэгдэн орсноор эрүүгийн процесст мөрдөх болсон юм. Нэрд гарсан соён гэгээрүүлэгчид, сэтгэгчид, гүн ухаантнууд хүн, түүний эрхийн асуудалд онцгой анхаарч байсан.

Тухайлбал, Германы гүн ухаантан И.Кант “...иргэний нийгэм нь угтаа агуу



ᠮᠤᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠰᠤᠭᠤᠰᠤᠨ ᠰᠤᠭᠤᠰᠤᠨ

их эрх чөлөө юм. Эрх чөлөөний эрх зүйн үндэс нь хүний эрх, эрх чөлөө юм. Энэ эрх, эрх чөлөө халдашгүй ариун байх ёстой” (Жанцан, 2008) гэж сургасан. Профессор Г.Совд "хүн бүр халдашгүй чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх...энэ эрх бол хүн бүрд Үндсэн хуулиар баталгаажуулсан хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх..." (Совд, 1999) гэж түүний эрх зүйн агуулгыг оновчтой тодорхойлжээ.

Эрүүдэн шүүхээс ангид байхыг “бие махбодын хүчирхийлэл үйлдэх” гэсэн хэвшмэл ойлголтоор өдийг хүртэл ирсэн нь шинэ төрлийн эрүүдэн шүүх хэлбэрийг танихгүй, хууль зүйн дүгнэлт өгөх боломжгүй байдалд хүргэсээр байна. Гэтэл зодож, занчиж, заналхийлсэн үетэй яг ижил үр дүнд хүргэдэг эс үйлдэхүйгээр буюу оролцогчийн эрхийг санаатайгаар эдлүүлэхгүй байх гэсэн шинэ эрүү шүүлтийн хэлбэрийг таних, дүгнэх чадамжгүй болсон. Эрх зүйд аливаа шинэ ухагдахуун, үзэгдэл нэвтэрвээс мэдрэг, даруй хандах ёстой. Энэ нь хэтэд хүний эрх улам зөрчигдөхөөс сэргийлэхээс гадна, хууль хэрэгжүүлэгчдийн эрх зүйн ухамсар, соёлд эерэг үр дүнтэй.

Шударгаар шүүлгэх эрх нь жам ёсны эрхийн нэгэн адил хүний салшгүй эрх, эрх чөлөөний асуудал бөгөөд зөвхөн хуульд л заасан үндэслэл, журмын дагуу л шалгагдах байдлаар хэрэгждэг өвөрмөц эрх мөн.

Шударгаар шүүлгэх эрхийн чиглэлээр дагнасан судалгаа хийгдэж, нэгдсэн ойлголтыг өгөөгүйгээс түүний хэрэгжилт практикт хангагдахгүй байсаар байна. Үүний тод жишээ нь хүний эрхийн болоод прокурорын байгууллагад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдоос гаргаж буй

гомдол, хүсэлтийн тоо өссөнөөс харж болно.

Шударгаар шүүлгэх эрх нь бүрдлийн, нэгдмэл шинжтэй. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс эхлэн, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл орон зайд хэлбэрэлтгүйгээр хангагдах учиртай. Энэ оройн зайд ялимгүй зөрчил гарч, түүнийг зөвтгөөгүй л бол шударгаар шүүлгэх эрх хангагдаагүй гэж үзнэ. Гэвч харамсалтай нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид ялимгүй зөрчлийг огоорох хандлага төлөвшөөд хэдийн уджээ.

Энэ нь чиглэлийн судалгаа хангалтгүй, уг эрхийн зөрчлийг таних, хууль зүйн дүгнэлт өгөх мэдлэг, чадвар, эрх зүйн ухамсар, соёл хангалтгүйтэй шууд холбоотой. Хамгийн гол нь хууль зүйн дүгнэлт өгөх шударгаар шүүлгэх эрхийн тухай нэгдсэн ойлголт байхгүй нь энэ чиглэлээр судлах хэрэгцээ, шаардлагыг бий болгоно.

Үндсэн хэсэг

Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай эсэхийг нотлох зорилгоор Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг удирдлага болгон төр, түүнийг төлөөлсөн байгууллага эрүүгийн процесс явуулах үед зайлшгүй хүний халдашгүй болон бусад эрх хөндөгдөх, хязгаарлагдах эрх зүйн үндэслэл бий болдог.

Халдашгүй байх нь хүний жам ёсны болоод үндсэн эрхийн нэг хэлбэр мөн. Халдашгүй байх эрхийн асуудал аливаа хүнийг гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байх үед ч хадгалагдсаар байдаг онцгой эрх юм. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шалгах явцад түүний зарим эрхэд хязгаарлалт тогтоох нь халдашгүй эрхийг зөрчиж буй хэрэг огтоосоо биш бөгөөд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжиж байгаагаар халдашгүй эрхийн баталгаа

болдог. Хүний эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах нөхцөл, хэрэгжилт нь түүний шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийг тодорхойлно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх зайлшгүй хөндөгдөх болдог. Гэхдээ энэ нь гагцхүү хуульд заасан тохиолдолд л яригдах асуудал юм.

Хүний халдашгүй эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулийн түвшинд, хязгаарлалтын хязгаарлалт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд тус тус тодорхойлогдоно (Эрдэнэбат, 2002). Иймд хүний халдашгүй эрхийг хамгийн товчоор хүний хүсэл зоригийн хуульчлагдсан илэрхийлэл болохын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд онцгойлон авч үзэх шаардлагатай (Жанцан, 2008). “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад гол зүйл бол хязгаарлалтыг хортойгоор ашиглах явдлыг гаргуулахгүй байх асуудал чухал юм” (Амарсанаа, 2000) гэж тус тус тодорхойлсон нь эрүүгийн процессын хүрээг тодорхой болгох нь хүний эрхийг хангах бас нэгэн арга хэрэгсэл гэдгийг онцолжээ.

Эрүүгийн процесс нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрд зохих ялыг шударгаар ногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэгч субъект болох мөрдөгч, прокурор, шүүгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаа юм.

Шударгаар шүүлгэх эрхийн асуудлыг зөвхөн шүүхийн шатанд хэрэглэгддэг, эсхүл эрүү шүүлт тулгах гэмт үйлдэлтэй холбон авч үздэг хэвшмэл байдлаас болж түүний мөн чанарыг бодитой тодорхойлж чадаагүй болох нь ажиглагддаг.

Монгол Улсын Үндсэн хуульд: “...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх...” эрхтэй болохыг тунхагласан. Мөн “...Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.” (Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948) “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966) гэж тус тус заажээ.

Эдгээрээс шударга шүүхээр шүүлгэх эрх үү, аль эсхүл шударгаар шүүлгэх эрх үү? гэх асуулт урган гарна. Судлаачийн зүгээс шударгаар шүүлгэх эрх нь оновчтой нэршил бөгөөд шүүх шударга байх боломжгүй гэж үзсэн.

Учир нь шүүх зөвхөн мөрдөн байцаалтын ажиллагааны үр дүнд бий болсон хавтаст хэргийн хүрээнд шийдвэр гаргадаг. Хэрэв тухайн хавтаст хэрэгт авагдсан аливаа баримтад мэдээлэл, нотлох баримт нь шударга бусаар цугласан бол түүнд үндэслэн гаргах аливаа шийдвэр шударга байх ямар ч боломжгүй. Иймээс шүүхийн шийдвэрийн үндэс болсон хавтаст хэргийн бүрдүүлбэр, нотлох ажиллагаа шударга байхын тухай ойлголт нь илүү бодитой учир шударгаар шүүлгэх эрх хэмээх нь гарцаагүй. Шударгаар шүүлгэх эрхийн асуудал нь нэгжийн шинжтэй эрхийн асуудал биш ба тогтолцооны шинжтэй. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл





ᠮᠤᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

бүртгэгдэхээс эхлээд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл бүхий л цаг хугацаа, орон зайд агуулагддаг онцгой эрх юм.

Үндэсний хууль тогтоомжид шударга шүүхээр шүүлгэх эрх гэж тодорхойлсноос шүүхэд хамаарах, шүүх шударга байх тухай гажуу үзэл баримтлал газар авсантай холбоотойгоор түүний жинхэнэ мөн чанарыг танин мэдээгүйгээс, тогтолцооны хямрал үүсгэхэд хүргэсэн. Шүүх л шударга байхын төлөө гэсэн лозунг дор түүний гаргаж буй шийдвэрийн үндэс болдог хавтаст хэргийг бүрдүүлж буй үйл ажиллагааны мөн чанарыг орхигдуулсантай холбоотой.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дах хүний эрхийг хангах асуудал нь шүүхийн шударга байхтай шууд холбогдоно. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед л цуглуулсан нотлох баримт хуульд заасан үндэслэл, журмын дагуу бэхжүүлэгдэж байж сая түүнийг үндэслэж гаргаж буй шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэл тодорхойлогдоно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа нь тус бүртээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж буюу үнэн, шударга байж үр дүн нь агуулгын хувьд үнэн, шударга байх боломжтой. Гагцхүү үүнд л шударгаар шүүлгэх эрхийн мөн чанар оршино.

Шударгаар шүүлгэх эрхийг нар хэмээн төсөөлбөөс түүний цацраг бүр нь эрүүгийн процессын хүрээнд хийгдэж буй нэгж ажиллагаанууд гэж ойлгох учиртай. Тэдгээр нэгж ажиллагаанууд бүгд хүний эрхийг хангаж байж сая шударгаар шүүлгэх эрх хангагдсан гэж үзнэ. Хэрэв зээ цацраг бүрд доголдол үүсвэл нар

гэхгүй, харин тэргэл саран болон хувирна. Бид олон жил тэргэл сарыг нар гэж итгэж, андуурч ирсэн. Бөөрөнхий, гэрэл цацруулж л байвал нар мөн гэх болов. Үнэн хэрэгтээ жинхэнэ нар жаргаад хэдийн удаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэхийг харгалзан бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь, тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж, санал, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах; бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нотлох баримтаар тооцохгүй байх; тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нь нотлох баримтаар тооцохгүй байх зэрэг шийдвэрийн аль нэгийг гаргах эрх хэмжээ шүүхэд байдаг. Энэ эрх хэмжээ нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хүний эрхийг зөрчихгүй байх гэсэн алтан зарчмыг алдагдуулахад хүргэсэн. Хуульд ийм агуулга бүхий зохицуулалт байгаа учраас төгс ажиллагаа явуулахад эрмэлзэхгүй нь мэдээж. Энэ мэт нь үргэлжилсээр хүний эрхийн зөрчилд мэдрэг бус хандах сөрөг үр дагавартай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчид ямагт хүний эрхийг зөрчихгүй байхад онцгой анхаарах ёстой байтал хуулийн дээрх зохицуулалтын үр дүнд хойрго хандаж, улмаар шүүх зөвтгөчих юм чинь гэсэн хоноцын сэтгэлээр аливааг гүйцэтгэх болсон. Өөрөөр хэлбэл, үр дүнд чиглэсэн хууль бус ажиллагааг газар авахад хүргэжээ.



Шударгаар шүүлгэх эрх нь мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс авч хэрэгжүүлж буй хуульд заасан ямар ч ажиллагааны үндэслэл нь бодитой, хэрэгжүүлж буй журам нь хуулиар зөвшөөрсөн хүрээнд явагдаж байж сая үр дүн нь нотлох баримт гэж үзэх учиртай. Бүхий л ажиллагаа үндэслэл, журмын дагуу явагдаж байж үр дүн нь шударга гарна. Өөрөөр хэлбэл, үр дүнд бус процессын үнэнд чиглэсэн эрмэлзэл, хандлага, гүйцэтгэл байх шаардлагатай юм.

Хавтаст хэрэгт авагдсан аливаа нотлох баримтыг бэхжүүлсэн аливаа ажиллагаа шударга бус буюу хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин буй ялимгүй үйлдэл ч шударгаар шүүлгэх эрхийн зөрчил гэж дүгнэгдэх ёстой.

Хэрэг бүртгэлтийн үед шударгаар шүүлгэх эрхийн илрэл.

Хэрэг бүртгэлт гэх үе шат нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авахаас эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл орон зайг хэлдэг. Энэ хүрээнд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авах, түүнийг бүртгэх, хяналт тавих, хойшлуулшгүй тохиолдолд хэрэгжүүлэх бүхий л ажиллагаанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжих ёстой. Зарим талаараа хууль зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүй бол хүний эрхэд суурилсан хандлагаар авч үзэж шийдвэрлэх эрмэлзэл, хандлага, зоригт үндэслэн тодорхой шийдвэр гаргахаар илэрхийлэгдэнэ.

Эдгээрээс гадна, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах удирдлага, зохион байгуулалтын оновчтой байдал ч үүнд хамаарна.

Одоогийн байдлаар гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг программ хангамжид бус нэгжийн даргын

үзэмжээр мөрдөгчид хуваарилж буй байдал нь зарим төрлийн эрсдэлийг бий болгосоор байна. Тухайлбал, ашиг сонирхлын үүднээс мөрдөгчийн нэр зааж гомдлыг шалгуулах, тодорхой этгээдийн хэргийг субьектив сонирхол бүхий мөрдөгчөөр шалгуулах зэрэг болно. Иймээс мөрдөгчид хуваарилагдаж буй гомдол, хэрэг бүртгэлтийн хэргийг тохиолдлын журмаар хуваарилах хэрэгцээ шаардлага байсаар байна. Энэ тохиолдолд шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх нөхцөл байсаар байгааг харуулна.

Мөрдөн байцаалтын үед шударгаар шүүлгэх эрхийн илрэл.

Мөрдөн байцаалтын үе шатад эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тухай тогтоол гарснаас хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл цаг хугацаа, орон зайг хамруулдаг.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ялгаа зааг тодорхой боловч агуулгыг нь тодорхойлж өгөөгүйгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрэгжүүлэгчдийн зүгээс чиг үүрэгтээ ашигтай байдлаар бусдын эрхийг хязгаарлах тохиолдол гаарсаар байна. Чухамхүү хэрэг бүртгэлтэд ямар ажиллагаа хийх боломжтой, харин ямрыг нь хийж болохгүй зэрэг зааг ялгааг хуульчилж өгөөгүй. Үүний улмаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоолыг үндэслэл хангалтгүй байсан ч гаргадаг хандлага газар авав.

Энэ нь үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тухай тогтоол гаргасан хяналтын прокурорт ямар нэгэн хууль зүйн хариуцлага байдаггүйтэй холбоотой.

Гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэх хүртэл тоолдог болсон гаж тогтолцооноос үүдэн мөрдөгч,



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

прокурор хэргийг “шуурхай” шийдвэрлэх ямар ч эрмэлзэлгүй болсон. Хөөн хэлэлцэх хугацаа дөхөөд ирэхэд яллагдагчаар татчихдаг буруу тогтолцоо бүрдсэн. Энэ нь хүнийг хууль ёсны хүрээнд эрүүдэн шүүж буй хэлбэрт шилжсэн.

Хэрэг бүртгэлтийн ажиллагаа бүрэн бодитой явагдсаны үндсэн дээр яллагдагчаар татах учиртай, гэтэл мөрдөн байцаалтын явцад хэрэг бүртгэлтийн шатанд хийж гүйцэтгэх ёстой байсан ажиллагаануудыг нөхөн гүйцэтгэж байгаа нь хүнийг үндэслэлгүйгээр яллагдагчаар татсанд тооцогдоно. Өөрөөр хэлбэл, урьдаар яллагдагчаар татчихаад, яллагдагчаар татсанаа дараа нь зөвтгөж, шаардлагатай нотлох баримтыг цуглуулж байна гэсэн үг юм.

Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэргийг эцэслэн шийдвэрлэх эрх хэмжээ прокурорт байдаг нь мөрдөх чиг үүргийн байгууллага байх шаардлагагүйг шууд илтгэнэ. Энэ нь прокурорын байгууллагын хяналтын чиг үүрэг гүйцэтгэх шинжтэй болсны илрэл юм.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явц дах шударгаар шүүлгэх эрхийн илрэл.

Шударгаар шүүлгэх эрхийн чухал баталгааны нэг нь шүүхийн хараат бус байдал чухал нөлөөтэй. Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхэд төрийн оролцоо ач холбогдолтой ч шүүх өөрөө санаачилгатай оролцох ёстой.

Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой арга зүй байдаг ч, манай улсын хувьд төдийлөн хэрэгжүүлэхгүй байгаа нь сөрөг үр дагаврыг дагуулсаар байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд шүүхтэй холбоотой хууль тогтоомжид багагүй өөрчлөлтүүд орсон ч

судалгааны агуулгад тохирно гэж үзэж, зарчмын шинжтэй 2 өөрчлөлтийг авч үзэхээр болов. Учир нь эдгээр өөрчлөлтүүд, онцгой, илүүтэйгээр хүний эрхийн зөрчлийг бий болгосон гэж судлаачийн зүгээс үзсэнтэй холбоотой.

Нэгдүгээрт хэргийг гэм буруугийн шүүх хуралдааны шатнаас нэмэлтээр мөрдөн байцаалтад буцаах боломжгүй зохицуулалт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлтээр оруулсан өөрчлөлтөөр гэм буруугийн шүүх хуралдаанаас хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах боломжгүй болсон (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017).

Энэхүү зохицуулалт нь хэргийг шуурхай шийдвэрлэх ач холбогдолтой мэт боловч нөгөө талдаа эрүүгийн процессын хүрээнд эрх зүйн соёл, ухамсар сонгодог утгаараа төлөвшөөгүй одоо үед хүний эрхийг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлж байна. Энэ нь бүрэн бус нотлогдсон хэргийг буцаах боломжгүй нөхцөл байдлын улмаас шийдвэрлэж бусдын эрхийг зөрчих зэрэг нөхцөл байдал дагуулах нь ойлгомжтой.

Шүүх аливаа эргэлзээ бүхий нөхцөл байдалтай хэргийг зоригтой шийдвэрлэж байх нь шүүх л шийдэг гэж хөнгөн ханддаг мөрдөгч, прокурорын хандлагыг өөрчилж, зөвхөн хуульд захирагдах эрх зүйн соёл төлөвшихөд тустай.

Хоёрдугаарт хяналтын шатны шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх шаардлагыг нэмэгдүүлсэн, мөн хяналтын шатны шүүхийн шийдвэрийг дахин хянан хэлэлцүүлэх тусгай журмыг хүчингүй болгосон зэрэг болно. Олон улсын хүний эрхийн байгууллагаас дээд шатны шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломж нь нээлттэй байх тусмаа хүний эрхийг хангаж байна гэж зөвлөдөг бол манай



Ապրիլի 20-ին

улсад эсрэгээрээ, Улсын дээд шүүхийн босгыг улам өндөрсгөж орхисон нь хүний эрхийн зөрчил болжээ.

Улсын дээд шүүхийн шийдвэрийг хянах тогтолцооны талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дах хэсэгт: “...Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно...” хэмээн зааж өгсөн боловч хэрэгжилтийг хангаж байсан ЭХХШТХ-ийн 40.10-40.12 дугаар зүйлийг 2021.01.15-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болгосон. Үүний үр дүнд Улсын дээд шүүхийн шийдвэр ямар ч агуулгатай гарсан бай (бүр хууль зөрчсөн байсан) түүнийг хянах тогтолцоо үгүй болсон. Салбарын хуульд хянах тогтолцоог хүчингүй болгосон ч Үндсэн хуульд байгаа агуулгаар хандаж болох эрх нээлттэй байгааг мартах учиргүй.

Дээр дурдсанчлан, шүүх шударга байх ямар ч боломжгүй. Шүүхийг тодорхой тооны шүүгч илэрхийлж байгаа энэ цаг үед ашиг сонирхлын зөрчил бий болох эрсдэлийг үгүйсгэх аргагүй. Тодруулбал, хяналтын шатны шүүх 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэргийг олонхоор шийдвэрлэдэг. Хэрэв уг 5 шүүгчийн 3 шүүгчийг нь ашиг сонирхлын үүднээс нэгтгэж чадвал ямар ч агуулга бүхий шийдвэрийг гаргуулах боломжтой. Өөрөөр хэлбэл, 3 шүүгчийн үзэмжид Монголын шүүх эрх мэдэл, институт оршиж буй хууль, эрх зүйн орчин бүрдүүлжээ. Шүүх эрх мэдэл ийм эмзэг байх учиргүй.

Харин өмнөх хуулийн зохицуулалт нь хяналтын шатны шүүхийн шийдвэр хууль зөрчсөн нь тодорхойлогдвол түүнийг хянаж, бүх шүүгчдийн хурлаараа зөвтгөх боломж нь нээлттэй байсан.

Энэ мэтчилэн, шударгаар
шүүлгэх эрхийн нэгдсэн ойлголт бий

болж, төлөвшөөгүйгээс түүний зөрчлийг таних, уг эрхийг хангах асуудал орхигдсоор иржээ. Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт нь хуульд заасныг ягштал баримтлаад хангалтгүй ба хүний эрхэд суурилсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхээс эхлэх учиртай.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. “Шударга шүүх” гэх ойлголт нь парадокс болох нь үндэсний эрх зүйн тогтолцоо, эрүүгийн процессын загварт хийсэн судалгааны дүнд тодорхойлогдож байна. Өөрөөр хэлбэл, аливаа шийдвэрийн амин сүнс нь шүүгчийн дотоод итгэл үнэмшил бөгөөд эрх зүйн ухамсрыг удирдлага болгон, зөвхөн хавтаст хэргийн хүрээнд л ямарваа нэгэн шийдвэрийг гаргадаг. Хэрэв хавтаст хэрэгт шударга бус арга хэрэгслээр нотлох баримт цуглуулсан бол тэдгээрийг үндэслэж гаргах шийдвэр нь ямар ч байсан шударга байх боломжгүй. Иймээс шүүх шударга байх боломжгүй бөгөөд харин шударгаар шүүлгэх эрхийн асуудал хөндөгдөнө.

2. Шударгаар шүүлгэх эрх нь нэгжийн бус, бүрдлийн шинжтэй жам ёсны эрх мөн. Гэмт хэрэг анх бүртгэгдсэн цагаас эхлэн гэмт хэрэг мөрдөх төрийн чиг үүргийн бүхий л үе шатад гагцхүү хуулийг баримталсан, хүний эрхэд суурилсан хандлага, тогтолцоо бүхий байдлаар илэрхийлэгддэг өргөн цар хүрээ бүхий шинжийг агуулдаг. Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн нь бусад нотлох баримтаар тогтоогдож байгаа хэдий ч зарим нотлох баримт цуглуулахдаа хууль зөрчсөн л бол шударгаар шүүлгэх эрхийн зөрчил гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, энэ эрхийн мөн чанар нь гэм буруутай эсэх нь дараагийн асуудал, урьдаар эрүүгийн процессын оролцогчийн хувьд ямар эрх, үүрэг эдлэх ёстой, тэр



бүгдийг гарцаагүй эдлүүлж байж сая хангагддаг.

3. Эрүүдэн шүүхээс ангид байх эрх нь шударгаар шүүлгэх эрхийг бүрдүүлэгч чухал хэсэг мөн. Энэ эрх нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдэн, шалгагдаж байгаа этгээдэд хамааралтай гэвэл өрөөсгөл юм. Мөрдөх институтын чиг үүрэгт хамаарч, оролцож байгаа бүхий л субъектэд хамаарна. Учир нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгчийн эрхийг хангасны үндсэн дээр бэхжүүлсэн нотлох баримтаар л гэмт хэрэгтнийг буруутгах, эрхийг нь хязгаарлах үндэслэл бий болдог зүй тогтолтой.

4. Шударгаар шүүлгэх эрхийг хангахад эрүүгийн процессын тодорхой хуульчилсан байдал туйлын чухал болохыг судалгааны үр дүн тодорхой харуулав. Учир нь эрүүгийн процесст хүний эрхийг хөндөх хил, хязгаарыг тодорхой болгож өгөөгүйгээс хэрэгжүүлэгчийн зүгээс дур зорго бий болж, чиг үүрэгтээ ашигтай байдлаар хэм хэмжээг тайлбарлаж, хэрэглэх хандлагатай болдог аж.

Ашигласан материал

Амарсанаа, Ж. (2000). *Хүний эрх: олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал*. Улаанбаатар.

Жанцан, С. (2008). Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх. *Хууль дээдлэх ёс*, 9.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2200А (XXI) тогтоол 1966 оны 03 23).

Сайнбаяр, Н. (2024). *Хүний эрхэд суурилсан мөрдөн шалгах ажиллагаа*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Совд, Г. (1999). Монгол Улсын Үндсэн хууль. *Хүний эрх*, 50-51 дэх тал.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 10 дугаар зүйл (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217А (III) тогтоол 1948).

Эрдэнэбат, Х. (2002). *Хүний халдашгүй эрх*. Улаанбаатар.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт өөрчлөлт (Улсын их хурал 2017).